БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ИХ БОГДЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: БНА-2021/173/СТА/ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Б.Цэрэнчимэд

Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ............ 3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ............ 5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ............ 5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............ 6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан............ 7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............ 9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 9
2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан............ 10
3.Аудитын тайлан............ 11
3.1. Ерөнхий зүйл ............ 11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ............ 11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ............ 11
3.4. Материаллаг байдал ............ 12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ............ 12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт............ 13
3.7. Шилэн дансны мэдээлэл............ 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............ 15
Залруулсан алдаа ............ 15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил............ 15
Аудитын зөвлөмж ............ 16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ............ 16
4. Менежментийн захидал............ 16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт............ 18

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.17 № 2/29

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИХ БОГДЫН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Т.ГАНБОЛД ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн

005021050

тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **49,613,741.55** | **39,493,585.80** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 49,613,741.55 | 39,493,585.80 |
| **351** | **Түүхий эд материал** | 24,569,306.00 | 25,706,856.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 24,569,306.00 | 25,706,856.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 25,044,435.55 | 13,786,729.80 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 648,200.00 | 604,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,973,540.25 | 5,421,039.20 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 77,900.00 | 77,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 383,978.60 | 6,527,390.60 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,960,816.70 | 1,156,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,826,895.13** | **50,121,496.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 53,826,895.13 | 50,121,496.18 |
| **392** | **Биет хөрөнгө** | 53,826,895.13 | 50,121,496.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,370,117.88 | 5,370,117.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -134,253.00 | -268,506.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 70,516,615.00 | 90,012,115.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -54,930,562.07 | -63,608,869.26 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 65,451,092.59 | 65,451,092.59 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -37,572,964.60 | -49,420,874.89 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,902,194.91 | 14,902,194.91 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,775,345.58 | -12,315,774.05 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,699,410.00 | 1,699,410.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,699,410.00 | -1,699,410.00 |
| 39301 | Програм хангамж | 695,000.00 | 695,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -695,000.00 | -695,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **103,440,636.68** | **89,615,081.98** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **150,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 150,000.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 150,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 150,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **103,440,636.68** | **89,465,081.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 103,440,636.68 | 89,465,081.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 36,953,494.00 | 36,953,494.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 36,953,494.00 | 36,953,494.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 65,367,024.56 | 51,391,469.86 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 65,367,024.56 | 65,367,024.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -13,975,554.70 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,120,118.12 | 1,120,118.12 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **103,440,636.68** | **89,615,081.98** |



005

## 2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **269,729,616.52** | **362,406,825.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,991,816.52** | **21,074,133.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,991,816.52 | 21,074,133.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 31,991,816.52 | 21,074,133.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,383,620.00 | 636,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 28,809,147.52 | 168,100.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,799,049.00 | 20,269,933.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **237,737,800.00** | **341,332,692.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 223,291,400.00 | 325,440,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 223,291,400.00 | 325,440,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,446,400.00 | 15,892,092.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 10,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,446,400.00 | 5,892,092.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **252,500,152.61** | **376,382,379.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **252,500,152.61** | **376,382,379.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 209,981,568.61 | 315,214,406.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 142,822,609.00 | 203,174,354.82 |
| 210101 | Үндсэн цалин | 142,822,609.00 | 203,174,354.82 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,566,972.00 | 24,743,307.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,224,472.00 | 18,622,423.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,603,300.00 | 2,080,673.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,282,600.00 | 1,541,246.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 320,700.00 | 396,139.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,135,900.00 | 2,102,824.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 562,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 562,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,814,987.00 | 35,094,389.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,895,528.00 | 1,959,320.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,183,841.00 | 13,191,988.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 672,600.00 | 1,462,231.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 63,018.00 | 86,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 18,394,050.75 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,696,200.00 | 3,589,904.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,696,200.00 | 3,589,904.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,405,500.00 | 2,273,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,405,500.00 | 2,273,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,459,705.07 | 22,576,552.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,447,850.07 | 21,172,952.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 148,455.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 467,400.00 | 237,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 396,000.00 | 1,031,850.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,215,595.54 | 23,200,898.95 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 467,000.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,748,595.54 | 23,200,898.95 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 42,518,584.00 | 61,167,972.88 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,628,900.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 27,628,900.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,889,684.00 | 61,167,972.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,491,604.00 | 55,275,880.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **17,229,463.91** | **-13,975,554.70** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **17,229,463.91** | **-13,975,554.70** |

## 2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **239,121,420.00** | **342,136,892.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,383,620.00** | **804,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,383,620.00 | 804,200.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,383,620.00 | 804,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,383,620.00 | 636,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 168,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **237,737,800.00** | **341,332,692.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 223,291,400.00 | 325,440,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 223,291,400.00 | 325,440,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,446,400.00 | 15,892,092.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 10,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,446,400.00 | 5,892,092.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **239,121,420.00** | **342,136,892.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **239,121,420.00** | **342,136,892.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **196,602,836.00** | **280,968,919.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 141,649,681.00 | 183,680,297.13 |
| 210101 | Үндсэн цалин | 114,771,373.00 | 143,527,887.73 |
| 210102 | Нэмэгдэл | 18,359,775.00 | 29,040,220.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,216,430.00 | 8,121,300.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,302,103.00 | 2,990,888.87 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,739,900.00 | 21,874,397.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,397,400.00 | 13,762,080.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,603,300.00 | 2,080,673.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,282,600.00 | 1,663,987.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 320,700.00 | 396,139.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,135,900.00 | 3,971,516.31 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 562,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 562,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,345,300.00 | 19,253,281.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,021,000.00 | 352,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,403,882.00 | 17,211,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 672,600.00 | 1,630,231.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 247,818.00 | 60,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 277,200.00 | 277,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 277,200.00 | 277,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,460,200.00 | 00.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 302,900.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,157,300.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,405,500.00 | 2,273,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,405,500.00 | 2,273,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,258,055.00 | 52,720,473.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,246,200.00 | 52,098,723.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 148,455.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 467,400.00 | 237,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 396,000.00 | 250,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 467,000.00 | 328,470.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 467,000.00 | 328,470.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,518,584.00** | **61,167,972.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,628,900.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 27,628,900.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,889,684.00 | 55,275,880.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,491,604.00 | 55,275,880.88 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 5,892,092.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 5,892,092.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 36,953,494.00 | 1,120,118.12 | 48,137,560.65 | 86,211,172.77 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **36,953,494.00** | **1,120,118.12** | **48,137,560.65** | 86,211,172.77 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 17,229,463.91 | 17,229,463.91 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **36,953,494.00** | **1,120,118.12** | **65,367,024.56** | 103,440,636.68 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **36,953,494.00** | **1,120,118.12** | **65,367,024.56** | 103,440,636.68 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **36,953,494.00** | **1,120,118.12** | **65,367,024.56** | 103,440,636.68 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -13,975,554.70 | -13,975,554.70 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **36,953,494.00** | **1,120,118.12** | **51,391,469.86** | 89,465,081.98 |

## 2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|
| | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | зөрүү | хувь |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 326,440,600.00 | 270,968,919.12 | -55,471,680.88 | 83.01 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 326,440,600.00 | 270,968,919.12 | -55,471,680.88 | 83.01 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 326,440,600.00 | 270,968,919.12 | -55,471,680.88 | 83.01 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 214,442,600.00 | 183,680,297.13 | -30,762,302.87 | 85.65 |
| Үндсэн цалин | 169,504,700.00 | 143,527,887.73 | -25,976,812.27 | 84.67 |
| Нэмэгдэл | 30,385,700.00 | 29,040,220.53 | -1,345,479.47 | 95.57 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 8,121,300.00 | 8,121,300.00 | 0.00 | 100.00 |
| Гэрээт ажлын хөлс | 6,430,900.00 | 2,990,888.87 | -3,440,011.13 | 46.51 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,949,800.00 | 21,874,397.99 | -7,075,402.01 | 75.56 |
| Тэтгэврийн даатгал | 20,372,100.00 | 13,762,080.38 | -6,610,019.62 | 67.55 |
| Тэтгэмжийн даатгал | 2,144,400.00 | 2,080,673.97 | -63,726.03 | 97.03 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,715,600.00 | 1,663,987.41 | -51,612.59 | 96.99 |
| Ажилгүйдлийн даатгал | 428,900.00 | 396,139.92 | -32,760.08 | 92.36 |
| Эрүүл мэндийн даатгал | 4,288,800.00 | 3,971,516.31 | -317,283.69 | 92.60 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 646,200.00 | 562,000.00 | -84,200.00 | 86.97 |
| Гэрэл, цахилгаан | 83,700.00 | 00.00 | -83,700.00 | 0.00 |
| Түлш, халаалт | 562,500.00 | 562,000.00 | -500.00 | 99.91 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 20,795,700.00 | 19,253,281.00 | -1,542,419.00 | 92.58 |
| Бичиг хэрэг | 1,056,000.00 | 352,050.00 | -703,950.00 | 33.34 |
| Тээвэр, шатахуун | 17,211,000.00 | 17,211,000.00 | 0.00 | 100.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,630,600.00 | 1,630,231.00 | -369.00 | 99.98 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 898,100.00 | 60,000.00 | -838,100.00 | 6.68 |
| **Нормативт зардал** | 277,200.00 | 277,000.00 | -200.00 | 99.93 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 277,200.00 | 277,000.00 | -200.00 | 99.93 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,952,900.00 | 00.00 | -1,952,900.00 | 0.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Багаж, техник, хэрэгсэл | 1,867,100.00 | 00.00 | -1,867,100.00 | 0.00 |
| Урсгал засвар | 85,800.00 | 00.00 | -85,800.00 | 0.00 |
| **Томилолт, зочны зардал** | 2,614,600.00 | 2,273,000.00 | -341,600.00 | 86.93 |
| Дотоод албан томилолт | 2,614,600.00 | 2,273,000.00 | -341,600.00 | 86.93 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 56,432,400.00 | 42,720,473.00 | -13,711,927.00 | 75.70 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 55,680,200.00 | 42,098,723.00 | -13,581,477.00 | 75.61 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 59,400.00 | 00.00 | -59,400.00 | 0.00 |
| Даатгалын үйлчилгээ | 148,500.00 | 133,950.00 | -14,550.00 | 90.20 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 294,300.00 | 237,800.00 | -56,500.00 | 80.80 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 250,000.00 | 0.00 | 100.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 329200.00 | 328470.00 | -730.00 | 99.78 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 329,200.00 | 328,470.00 | -730.00 | 99.78 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 326,440,600.00 | 270,968,919.12 | -55,471,680.88 | 83.01 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 325,440,600.00 | 270,164,719.12 | -55,275,880.88 | 83.02 |
| Улсын төсвөөс санхүүжих | 325,440,600.00 | 270,164,719.12 | -55,275,880.88 | 83.02 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 804,200.00 | -195,800.00 | 80.42 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 804,200.00 | -195,800.00 | 80.42 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 0.00 | 100 |
| Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 0.00 | 100 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 24.00 | 0.00 | 100 |
| Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100 |
| Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 16.00 | 0.00 | 100 |
| Үйлчлэх ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100 |
| Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100 |

## 2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **14,048,320.00** | **10,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,048,320.00** | **10,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 14,048,320.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,048,320.00 | 10,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,048,320.00 | 10,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 14,048,320.00 | 10000000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,048,320.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 10,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,048,320.00 | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Дарга Т.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав

Аудитыг 2021.02.01-ээс 2021.02.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.10.26-ны өдрийн 140 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн талаар сурталчлан таниулж, иргэдэд мэдээлэл хүргэх, салбарын байгууллагуудын хамтын оролцоог сайжруулах, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2018, 2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт шалгалтыг хийж 11 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 217613.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4352.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 376382.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7527.6 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1818.1 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 49,613.7 | 39,493.6 | (10,120.2) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 49,613.7 | 39,493.6 | (10,120.2) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 53,826.9 | 50,121.5 | (3,705.4) |
| Үндсэн хөрөнгө | 158,634.4 | 178,129.9 | 19,495.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (104,807.5) | (128,008.4) | (23,200.9) |
| **Нийт хөрөнгө** | 103,440.6 | 89,615.1 | (13,825.6) |
| Өр төлбөр | - | 150.0 | 150.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 103,440.6 | 89,465.1 | (13,975.6) |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 103,440.6 | 89,615.1 | (13,825.6) |

*Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авав/*

Бараа материалын дансны үлдэгдэл 3949366 мянган төгрөг болж 10120.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 8273.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдүүлж, 18394.0 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл178129.9 мянган төгрөг болж 19495.5 мянган төгрөгөөр өссөн нь БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн 19495.5 мянган төгрөгийн мотоциклийг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 89465.1 мянган төгрөг болж 13975.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 13975.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 362406.8 мянган төгрөг болж өмнөх оноос 90878.6 мянган төгрөгөөр буюу 33.47 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 90878.6 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 102149.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгийн санхүүжилт 12659.1 мянган төгрөгөөр буурсан, төсөвт байгууллагын өөрийн орлого 3445.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, нэмэлт санхүүжилтийн орлого 257.9 мянган төгрөгөөр буурсан зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

Нийт зардал 376382.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 122083.7 мянган төгрөгөөр буюу 48.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, тогтмол болон хангамжийн материал, урсгал засварын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 338725.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 338725.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 12284.4 мянган төгрөгөөр бууруулж 325440.6 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 338725.2 мянган төгрөг батлагдсанаас 2 удаагийн зохицуулалт

хийж 12284.4 мянган төгрөгөөр хасаж 325440.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 270164.7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж урсгал үйл ажиллагааны зардлаас 55275.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 270968.9 мянган төгрөг буюу 83.01 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 37837.7 мянга, тогтмол зардал 84.2 мянга, хангамжийн зардал 1542.4 мянга, эд хогшил урсгал засварын зардал 1542.4 мянга, албан томилолтын зардал 341.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 13711.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 55471.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний зардлыг 55471.7 мянган төгрөгөөр зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ДҮН** | **326,440,600.00** | **270,968,919.12** | **55,545,629.88** | **83.01** |
| ХӨТӨЛБӨР 71405 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 270,760,400.00 | 228,870,196.12 | 41,964,152.88 | 84.50 |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 270,760,400.00 | 228,796,247.12 | 41,964,152.88 | 84.50 |
| ХӨТӨЛБӨР 71405 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 80221 Гэрээт ажиллагсдын зардал | 29,857,200.00 | 22,212,967.00 | 7,644,233.00 | 74.40 |
| ХӨТӨЛБӨР 71405 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 13,481,500.00 | 11,522,550.00 | 1,958,950.00 | 85.47 |
| ХӨТӨЛБӨР 71405 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 81703 Ургамал хамгааллын зардал | 12,341,500.00 | 8,363,206.00 | 3,978,294.00 | 67.76 |

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт нэвтэрсэн иргэдийн төлбөр хураамжийн орлогоор 5892.1 мянган төгрөг, засаг даргын нөөц хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 10000,0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.

Үүнээс 5892.1 мянган төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлж, 10000,0 мянган төгрөгийг байгууллагын ажилтны орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээнд зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээлэл хугацаа болоогүй байна. 2020 оны 1-р улиралд 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг 47326,0 мянган төгрөгөөр 5-р сард 2658,2 мянга, 9-р сард 28088,7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй мэдээлсэн байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 2 | 0 | 1 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | | |
| 6 | Нийт | 27 | 151 | 147 | 3 | 0 | 1 |

*Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/*

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тус байгууллагын санхүүгийн тайланд “Итгэл” үзүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7898.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1171,1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6727.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 7898.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1171.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

1. Цалингийн түүвэр хийж НДШ, ХХОАТ, бусад суутгалын авлага өглөгийн тооцоог хийхэд НДШ зөрүүгүй, ХХОАТ-т 12854587 төгрөг суутгасан байхад Татварын хэлтэст 14025738 төгрөг буюу 1171151 төгрөг илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 6727.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал *данстай холбоотой асуудал*

*1.1* *Илрүүлэлт:* Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээлэл хугацаа болоогүй байна. 2020 оны 1-р улиралд 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг 47326,0 мянган төгрөгөөр 5-р сард 2658,2 мянга, 9-р сард 28088,7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6-р зүйлийн 6.1"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" заалтыг тус тус зөрчсөн байна.

*1.2* *Эрсдэл: Хөрөнгийн зарцуулалтын ил, тод байдлыг хангахгүй байх*

*1.3* Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн дагуу шилэн дансны мэдээллийн Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт хэсгийн цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг цаашид цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмж өглөө.

*1.4* *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.Хөрөнгийн данстай холбоотой асуудал

*2.1* Илрүүлэлт: Оны эхэнд 383,9 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байж 20560,5 мянган төгрөгийн шатахуун худалдан авч, 14417,1 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, , тайлант оны эцэст 6527,4 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байгаа нь бодит хэрэгцээнээс илүү шатахуун бэлтгэж нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6-р зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ТБОНАХБАҮХАТ хуулийн 5.1.24 "өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил үйлчилгээг хэлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.3 *Эрсдэл: Хөрөнгийн ашиглалт хангалтгүй, үр ашиггүй байх*

2.3 *Өгсөн зөвлөмж*: Тайлант хугацааны бодит хэрэгцээнээс илүү шатахуун худалдан авч нөөцлөхгүй байх, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: "Тухайн байгууллагад 200,0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ ашиглалтгүй байна.

Энэ нь Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271-р тогтоолоор батлагдсан журмын 6.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн тооллогын дүн, өмч хамгаалах комиссын дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан материалын хамт хагас жилд нэг удаа ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "**Оршин байх**" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл: Хөрөнгө дутагдах, эзэнгүйдэх

3.3 Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271-р тогтоолоор батлагдсан журмын 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж, ашиглалтгүй үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.15

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.15

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.15

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: 2020.12.31 | Аудитын нэр: | *2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит* | Аудитын код: БНА-2021/173/СТА-ТШЗ |
|---|---|---|---|
| Шалгагдсан байгууллагын нэр: | | *Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны* | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн түүвэр хийж ХХОАТын суутгалын авлага өглөгийн тооцоог хийхэд НДШ зөрүүгүй, ХХОАТ-т 12854587 төгрөг суутгасан байхад Татварын хэлтэст 14025738 төгрөг буюу 1171151 төгрөг илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил илэрлээ. | 1171.1 | Төлбөрийн акт | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Ганболд, С.Мөнхбаатар |
| 2 | Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээлэл хугацаа болоогүй байна. 2020 оны 1-р улиралд 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг 47326,0 мянган төгрөгөөр 5-р сард 2658,2 мянга, 9-р сард 28088,7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй мэдээлсэн байна. | | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Ганболд, С.Мөнхбаатар |
| 3 | Оны эхэнд 383,9 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байж 20560,5 мянган төгрөгийн шатахуун худалдан авч, 14417,1 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, , тайлант оны эцэст 6527,4 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байгаа нь бодит хэрэгцээнээс илүү шатахуун бэлтгэж нөөцөлсөн байна. | 6527.4 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Ганболд, С.Мөнхбаатар |
| 4 | Тухайн байгууллагад 200,0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ ашиглалтгүй байна. | 200.0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Ганболд, С.Мөнхбаатар |
| **ДҮН** | | **7898.5** | | | |



005